

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх
санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам”-ыг
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай” 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫЭРХЛЭХ САНХҮҮГИЙН БУСАД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэхэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн бусад ажил, үйлчилгээний нэр төрөл, түүнд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, ХЗХ-ноос холбогдох журмуудыг боловсруулахад зайлшгүй тусгах асуудлыг тодорхойлоход оршино.

1.2. ХЗХ нь санхүүгийн бусад ажил, үйлчилгээг Хорооны зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.

1.3. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх ХЗХ нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн түрээсийн /лизингийн/ тухай хууль, Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”, 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.4. ХЗХ нь санхүүгийн бусад ажил, үйлчилгээг зөвхөн гишүүддээ үзүүлнэ.

1.5. Энэ журамд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “санхүүгийн бусад ажил, үйлчилгээ” /цаашид “ажил, үйлчилгээ” гэх/ Хорооны 2012 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан ажил, үйлчилгээг;

1.5.2. “санхүүгийн түрээсийн үйлчилгээ” гэж ХЗХ нь гишүүдийнхээ хэрэгцээнд ашиглагдах, үр өгөөж өгөх хөрөнгийг гуравдагч этгээдээс худалдан авч, тодорхой нөхцөлтэйгээр гишүүндээ түрээслүүлэн, түрээсийн хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийг гишүүний өмчлөлд шилжүүлэх үйл ажиллагааг;

1.5.3. “төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ” гэж ХЗХ болон ХЗХ-ны гишүүдийн эрх ашиг, хэрэгцээг хангах зорилгоор бичил санхүү, орон нутгийн хөгжлийг дэмжих зориулалт бүхий төсөл, хөтөлбөрийг гишүүддээ дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээг;

1.5.4. “цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ” гэж ХЗХ нь гишүүдийнхээ бэлэн мөнгийг цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан цахим мөнгөн хэлбэрт хөрвүүлэх, буцаан хөрвүүлэх, мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоог түргэн шуурхай, баталгаатай гүйцэтгэх үйлчилгээг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрт хүргэх, цахим хэтэвч эзэмшигчдийн бүртгэл болон бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээг;

1.5.5. “цахим мөнгө” гэж Хорооны 2011 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”-ын 2.1.1-д тодорхойлсныг;

1.5.6. “цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч” гэж Хорооноос цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллагыг;

1.5.7. "даатгалын төлөөлөгч" гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор нэмсэн./

Хоёр. ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэхэд Хорооноос тавигдах нийтлэг шаардлага

2.1. ХЗХ нь эрхлэх ажил, үйлчилгээндээ дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. ~~Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 5.2 дахь заалтад заасан нөхцөл, шаардлага;~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

2.1.2. ажил, үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргахдаа Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 5.3 дахь заалтад заасан шаардлагад нийцсэн баримт бичгийн бүрдэл;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.1.3. ХЗХ-дын баталсан ажил, үйлчилгээнд мөрдөх журмууд нь Монгол Улсын Иргэний хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тухайн ажил, үйлчилгээтэй холбоотой бусад хууль тогтоомж, Хорооноос гаргасан заавар, журмын хүрээнд ХЗХ болон гишүүдийн эрх ашгийг хангахад чиглэгдсэн;

2.1.4. ажил, үйлчилгээнд мөрдөж буй журамд өөрчлөлт орсон тухай бүрд Хороонд мэдэгдэж бүртгүүлсэн.

2.2. ХЗХ нь тухайн ажил, үйлчилгээний холбогдох журам, заавруудад дараах асуудлуудыг зайлшгүй тусгасан байна:

2.2.1. шаардлагатай нэр томъёоны тайлбар, тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд ХЗХ-ноос тавигдах нөхцөл, шаардлага, оролцогч талуудын эрх үүрэг/бие биендээ харилцан итгэж, үнэн бодит мэдээллээр хангагдах, хууль дээдлэх, шударга байх үндсэн зарчмуудыг тодорхой тусгасан байх/, ажил, үйлчилгээний гэрээ байгуулах, дуусгавар болгох, хориглох зүйл, хяналт, хариуцлага;

2.2.2. нягтлан бодох бүртгэлийг Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, маягтын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гарган Хороонд ирүүлж байх, ажил, үйлчилгээнд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон Хорооноос баталсан холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах;

2.2.3. ХЗХ-ны гишүүдийг хуурамч мэдээллээр хангах, төөрөгдүүлэх, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг нуун дарагдуулах, өөрийн ажил үүрэгтэй холбоотой нийтэд тараагдаагүй мэдээллийг ашиглан ашиг олох, бусдад тараах, гишүүдээс төлбөл зохих үйлчилгээний хөлс болон зардлаас илүү хэмжээний төлбөр шаардахыг хориглох;

2.2.4. ХЗХ нь тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, харилцагчдын холбогдох гэрээ, хувийн хэрэг зэргийг хэрхэн бүрдүүлж хадгалж, хамгаалах;

2.2.5. ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээний хэрэгжилтэд ХЗХ-ны төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага дараалсан хяналтыг тогтмол тавих, бүх гишүүдийн хуралд тайланг танилцуулах;

2.2.6. холбогдох хууль тогтоомж, журмыг зөрчсөн үйл ажиллагаанаас гарсан хохирлыг тухайн ХЗХ-ны шийдвэр гаргасан удирдлага, санаатай болон санамсаргүй байдлаас гаргасан зөрчил, дутагдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гаргасан гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөөгүйгээс үүссэн хохирол, гарсан аливаа маргааныг холбогдох гэрээг үндэслэн холбогдох хууль тогтоомж, ажил хэргийн хүрээнд тогтсон зарчмын дагуу эрх бүхий хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

2.3. ХЗХ нь гишүүдтэй ажил, үйлчилгээний гэрээг бичгээр байгуулах ба гэрээнд дараах асуудлыг зайлшгүй тусгасан байна:

2.3.1. ХЗХ-ны нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утасны дугаар;

2.3.2. түрээслэгч гишүүн этгээд нь иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утасны дугаар;

2.3.3. түрээслэгч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утасны дугаар;

2.3.4. гэрээний хугацаа, төлбөрийн хэмжээ, оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, хамрах хүрээ, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах, нөхцлийг өөрчлөх хэлбэр, гэрээг хугацаанаас өмнө цуцлах нөхцөл, гэрээнд заасан нөхцөл хангагдсанаар гэрээ дуусгавар болгох, цуцлах нөхцөл, үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх, гэрээнд заасан үүргээ санаатайгаар биелүүлээгүй, хууран мэхлэх арга хэрэглэсэн, сахилга бат зөрчсөн гишүүдэд авах шат дараалсан арга хэмжээ.

2.4. ХЗХ-ны ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгоход Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх ба энэ харилцааг Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын дагуу хянан, шийдвэрлэнэ.

2.5. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа /ажил, үйлчилгээ/ эрхлэхтэй холбогдсон харилцааг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын дагуу зохицуулна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор нэмсэн/

Гурав. Ажил, үйлчилгээ тус бүрт тавигдах нэмэлт нөхцөл, шаардлага

3.1. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд дараах нэмэлт нөхцөл, шаардлагыг тусгасан байна:

3.1.1. түрээсийн зүйлийн нэр, техникийн үзүүлэлт, хэмжээ болон онцлог шинж;

3.1.2. санхүүгийн түрээсийн зүйлийг түрээслэгч /гишүүн/-д шилжүүлэх, баталгаат хугацааны болон түүний дараах үеийн засвар үйлчилгээ, түрээсийн зүйлийг буцаан авах нөхцөл;

3.1.3. түрээсийн төлбөрийн хэмжээ, түүнийг түрээслэгчид шилжүүлэх;

3.1.4. түрээслэгч /гишүүн/ нь үүргээ биелүүлээгүйн улмаас түрээслүүлэгч /ХЗХ/-д учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээнд заасан түрээслэгчийн санхүүгийн баримтыг хүлээн авах, түрээсийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй танилцах.

3.2. Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээн дараах нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан байна:

3.2.1. төсөл, хөтөлбөрөөс тавигдсан нөхцөл, шаардлагыг хангасан;

3.2.2. дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах, хангуулах;

3.2.3. зээлдэгч бүрт хувийн хэрэг нээж, хөтлөх;

3.2.4. дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хуваарийн дагуу дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүгийн болон үндсэн төлбөрийг хугацаанд нь төлөх.

3.3. Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ нь дараах нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан байна:

3.3.1. үйлчилгээний журамд Хорооны 2011 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам"-ын 5.5, 5.6 дахь заалтуудад заасан эрх, үүргийг тодорхой тусгасан байх;

3.3.2. ажлын байрандаа цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс олгосон таних тэмдэг бүхий батламж, дансны дугаар, үйлчилгээний үнийн саналыг гишүүдэд харагдахуйц газар байрлуулах.

3.4 Даатгалын төлөөлөгчийн ажил, үйлчилгээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-д заасан шаардлагыг хангасан байна.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор нэмсэн/

Дөрөв. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээнд хориглох зүйл

4.1. ХЗХ-ны эрхлэх ажил, үйлчилгээнд дараах зүйлсийг хориглоно:

4.1.1. гишүүн бус этгээдэд ажил, үйлчилгээ үзүүлэх;

4.1.2. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа болон энэ журамд зааснаас өөр бусад ажил, үйлчилгээ эрхлэх;

4.1.3. гишүүдийг ажил, үйлчилгээний талаарх буруу, дутуу мэдээллээр хангах, төөрөгдүүлэх;

4.1.4. гишүүдэд ажил, үйлчилгээ үзүүлснээс авбал зохих шимтгэл, хураамж, урамшууллаас гадна өөр бусад хэлбэрээр тэдгээртэй адилтгах бусад шимтгэл, хураамж, шан харамж хүртэх;

4.1.5. гишүүдэд үзүүлсэн ажил, үйлчилгээтэй холбоотойгоор нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, тараах.

Тав. Хяналт, хариуцлага

5.1. Хорооны хянан шалгагч нь энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомж, журмаар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд арга хэмжээг авч хариуцлага ногдуулна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО